



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/016/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn Аудитор: Ж.Мөнхбилгүүн Утас: 51-261628 Цахим хаяг: munkhbilguunj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Улсын авто замын сан	18
5.2 Харьяа байгууллага	18
5.3 Албан шаардлага	18
5.5 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗТХТ	Зам тээврийн хөгжлийн төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

2026.03.25 № 06/786
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын авто замын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Улсын авто замын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 7,382,869.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.4, 16 дугаар зүйлийн 16.5, 22 дугаар зүйлийн 22.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Нийт 370,846.4 мянган төгрөгийн авлага, 605,271.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Улсын авто замын сангийн эх үүсвэрээр 2020-2023 онд гүйцэтгэсэн 9 ажлын 1,092,344.5 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, бусад эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй;
- Улсын авто замын сангийн хөрөнгөөр 2020 онд гүйцэтгэсэн ажлын 775,156.8 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй;

- Нийт 4 гүйцэтгэгчтэй байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний урьдчилгаа төлбөр 4,398,259.7 мянган төгрөгийг гэрээнд заасан хугацаанд суутгаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын авто замын сан тайлант онд төлбөр хураах үйл ажиллагаанаас нийт 34,349,200.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсвөөс 47,794,975.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгийн зардалд 72,794,975.4 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны зардалд 5,356,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/63 дугаар тушаалаар "Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын 2025 оны төлөвлөгөө"-г баталж тус төлөвлөгөөг 2025 оны А/217, А/289, А/324 дүгээр тушаалуудаар тус тус шинэчлэн нийт зардлыг 72,794,975.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Бусад асуудал

Улсын хэмжээнд тайлант онд нийт 33 төлбөр авах цэг ажилласнаас 16 нь бүрэн цахимжсан, авто зам ашигласны төлбөрийг тээврийн хэрэгслийн эзэмшигч дээр www.ezam.mn сайт болон И-Монголиа системээр дамжуулан нэхэмжлэх үүсгэдэг байна. Цахим программ хангамжийг цаг тухай бүрт хөгжүүлэн, тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт төлбөр төлөх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, зам хэрэглэгчдэд хүртээмжтэй байлгахын тулд бүх банкны аппликейшн, цахим хэтэвч, цахим төлбөр тооцооны системийг хөгжүүлэн, И-Монголиа, И-баримт, ezam.mn, Гэрэгэ киоск, Кьюпэй, Токи зэрэг цахим төлбөр тооцооны системүүдтэй хамтран ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,336,423,997.66	6,392,738,495.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	59,653,807.51	182,119,531.44
312	Банканд байгаа бэлэн мөнгө	59,653,807.51	182,119,531.44
3121	Төгрөг	59,653,807.51	182,119,531.44
3122	Замд яваа мөнгөн хөрөнгө	1,970.00	-
33	АВЛАГА	360,313,201.02	4,149,520,115.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,575,022.12	31,789,525.84
335	Бусад авлага	350,738,178.90	4,117,730,589.40
3351	Байгууллагаас авах авлага	350,738,178.90	4,117,730,589.40
34	УРЬДЧИЛГАА	775,156,802.00	775,156,802.00
34600	Урьдчилж гарсан зардал	775,156,802.00	775,156,802.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,953,739.13	193,597,569.13
354	Хангамжийн материал	48,953,739.13	193,597,569.13
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,092,344,478.00	1,092,344,478.00
3680	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,092,344,478.00	1,092,344,478.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,609,472,679.42	7,168,642,738.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,609,472,679.42	7,168,642,738.79
392	Биет хөрөнгө	7,591,783,790.62	7,164,220,516.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,621,028,358.10	7,621,028,358.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(751,262,005.66)	(1,057,842,230.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	152,834,375.00	152,834,375.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,401,663.51)	(66,172,808.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,064,738,883.00	1,068,483,159.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(560,792,460.04)	(651,741,130.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	147,777,523.99	147,777,523.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,999,220.26)	(60,046,729.37)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,800,000.00	19,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,940,000.00)	(9,900,000.00)
393	Биет бус хөрөнгө	17,688,888.80	4,422,222.08
39301	Программ хангамж	26,660,000.00	26,660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,815,555.60)	(24,448,888.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,900,000.00	19,900,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(11,055,555.60)	(17,688,888.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,945,896,677.08	13,561,381,234.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	202,532,774.51	5,352,933,651.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	202,532,774.51	5,352,933,651.67
413	Өглөг	202,532,774.51	5,352,933,651.67
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	132,743,406.37	713,631,914.34
4136	Бусад өглөг	69,789,368.14	4,639,301,737.33
41361	Байгууллагад төлөх өглөг	69,789,368.14	4,535,864,719.17
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	103,437,018.16
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,743,363,902.57	8,208,447,582.93
51	Засгийн газрын хувь оролцоо	9,743,363,902.57	8,208,447,582.93
51200	Хуримтлагдсан үр дүн	9,358,812,545.56	7,823,896,225.92
51210	Өмнөх үеийн үр дүн	9,927,665,639.68	9,358,812,545.56
51220	Тайлант үеийн үр дүн	(568,853,094.12)	(1,534,916,319.64)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	384,551,357.01	384,551,357.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,945,896,677.08	13,561,381,234.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	65,176,461,912.57	87,388,107,220.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,703,287,012.57	87,388,107,220.85
120	Нийтлэг татварын бус орлого	28,703,287,012.57	39,593,131,820.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,665,223,398.85	39,592,299,183.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,665,223,398.85	39,592,299,183.76
120009	Бусад орлого	38,063,613.72	832,637.09
122	Тусламжийн орлого	-	47,794,975,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	47,794,975,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,473,174,900.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	36,473,174,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,473,174,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,837,588,411.69	12,549,707,324.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,837,588,411.69	12,549,707,324.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,798,160,707.84	12,501,047,398.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,719,751,259.80	4,414,222,138.08
210101	Үндсэн цалин	3,719,751,259.80	2,588,277,903.92
210102	Нэмэгдэл	-	1,825,944,234.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	704,211,043.32	550,412,221.39
210201	Тэтгэврийн даатгалын зардал	319,614,841.53	377,795,893.32
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	37,611,866.11	44,441,625.49
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	17,535,413.45	24,694,161.38
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	14,300,209.01	19,330,906.26
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	72,027,676.37	84,149,634.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,784,359.27	321,423,382.33
210301	Гэрэл, цахилгаан	170,568,192.56	318,000,882.33
210302	Түлш, халаалт	1,216,166.71	3,422,500.00
2104	Хангамжийн бараа материал	796,009,185.85	600,403,944.64
210401	Бичиг хэрэг	32,825,425.06	3,563,825.00
210402	Тээвэр, шатахуун	132,892,691.00	130,312,390.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	575,380,278.79	443,649,437.52
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,648,246.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,650,418.00	7,072,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	22,260,373.00	14,157,146.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	179,687,648.80	60,817,451.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,467,850.00	2,103,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,607,000.00	-
210604	Урсгал засвар	145,612,798.80	58,713,951.00
2107	Томилолт, зочны зардал	34,797,717.00	18,150,000.00
210701	Гадаад албан томилолт	14,476,059.00	-
210702	Дотоод албан томилолт	20,321,658.00	18,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,581,317.02	6,000,134,564.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,162,031.00	5,402,554,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	138,996.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	448,577.81	930,639.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,386,000.00	591,225,766.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	63,584,708.21	5,285,163.42

Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	279,459,213.63	535,483,696.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,107,773.56	76,337,780.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	14,571,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	199,851,440.07	444,574,216.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,039,427,703.85	48,659,926.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,910,000.00	48,659,926.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	21,933,490.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,010,000.00	7,876,436.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,900,000.00	18,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,866,971,703.85	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,866,971,703.85	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	149,546,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	149,546,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	51,338,873,500.88	74,838,399,896.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	7,700,000.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	7,700,000.00	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,915,426,595.00	76,373,316,216.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	51,915,426,595.00	76,373,316,216.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(51,907,726,595.00)	(76,373,316,216.00)
7	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(568,853,094.12)	(1,534,916,319.64)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	65,217,867,676.95	82,033,985,919.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,744,692,776.95	82,033,985,919.76
120	Нийтлэг татварын бус орлого	28,744,692,776.95	34,239,010,519.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,710,250,026.95	34,236,299,183.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,665,223,398.85	34,235,964,183.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,026,628.10	335,000.00
120009	Бусад орлого	34,442,750.00	2,711,336.00
122	Тусламжийн орлого	-	47,794,975,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	47,794,975,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,473,174,900.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	36,473,174,900.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,473,174,900.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,517,253,088.71	9,116,546,765.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,517,253,088.71	9,116,546,765.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,500,735,384.86	5,361,557,353.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	797,260,589.46
210201	Тэтгэврийн даатгал	-	542,137,200.83
210202	Тэтгэмжийн даатгал	-	63,780,847.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	31,890,423.58
210204	Ажилгүйдлийн даатгал	-	31,890,423.58

Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	-	127,561,694.31
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,327,738,097.19	4,564,296,763.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,327,738,097.19	4,564,296,763.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	172,997,287.67	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	172,997,287.67	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,016,517,703.85	3,754,989,412.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	3,754,989,412.40
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	3,754,989,412.40
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,866,971,703.85	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,866,971,703.85	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	149,546,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	149,546,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51,700,614,588.24	72,917,439,153.93
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	51,942,766,595.00	72,794,975,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,942,766,595.00	72,794,975,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	51,942,766,595.00	72,794,975,400.00
223001	Бусад хөрөнгө	51,915,426,595.00	72,794,975,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,340,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(51,942,766,595.00)	(72,794,975,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(242,152,006.76)	122,463,753.93
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	301,807,784.27	59,655,777.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,655,777.51	182,119,531.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	-	384,551,357.01	10,791,953,117.43	11,176,504,474.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(864,287,477.75)	(864,287,477.75)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	384,551,357.01	9,927,665,639.68	10,312,216,996.69
Тайлант үеийн үр дүн	-	-	(568,853,094.12)	(568,853,094.12)
2024 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	-	384,551,357.01	9,358,812,545.56	9,743,363,902.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	384,551,357.01	9,358,812,545.56	9,743,363,902.57
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,534,916,319.64)	(1,534,916,319.64)
2025 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	-	384,551,357.01	7,823,896,225.92	8,208,447,582.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	78,150,975,400.00	82,144,176,178.26	(3,993,200,778.26)	105.1
12	Татварын бус орлого	78,150,975,400.00	82,144,176,178.26	(3,993,200,778.26)	105.1
122	Нийтлэг татварын бус орлого	30,356,000,000.00	34,349,200,778.26	(3,993,200,778.26)	113.2
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	30,356,000,000.00	34,349,200,778.26	(3,993,200,778.26)	113.2
122	Тусламжийн орлого	47,794,975,400.00	47,794,975,400.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	47,794,975,400.00	47,794,975,400.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,150,975,400.00	78,150,975,400.00	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,356,000,000.00	5,356,000,000.00	-	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,356,000,000.00	5,356,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,356,000,000.00	5,356,000,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,356,000,000.00	5,356,000,000.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,794,975,400.00	72,794,975,400.00	-	100.0
223001	Бусад хөрөнгө	72,794,975,400.00	72,794,975,400.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-	3,993,200,778.26	(3,993,200,778.26)	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(3,993,200,778.26)	3,993,200,778.26	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(3,993,200,778.26)	3,993,200,778.26	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(59,655,777.51)	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	181,266,924.35	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	248	232	-	93.5
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10	9	-	90.0
620004	Гэрээт ажилтан	237	222	-	93.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын авто замын сан нь Авто замын тухай хуулиар олон улс, улсын чанартай авто замын нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчсон тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр хураамж авах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй, Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Улсын авто замын сан нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/63 дугаар тушаалаар А/217, А/289, А/324 тушаалаар баталсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу тайлант онд улсын чанартай зам арчлалт, засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд авто замын арчлалт, засварын ажилд төсвийн санхүүжилтээс гадна авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс төлбөр, хураамж, авах, үйл ажиллагааг цахим 16 цэг болон уламжлалт 17 төлбөр авах цэгээр дамжуулан сангийн орлогыг бүрдүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улсын авто замын сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Авто замын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны "Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох" 103 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/226 дугаар тушаалаар баталсан "Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам"-д нийцүүлэн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар;
- "Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам"-д нэмэлт оруулах тухай Зам, тээврийн сайдын 2023 оны А/273 дугаар тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сан нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг жишиг болгон мөрдөж ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,615,484.6 мянган төгрөгөөр буюу 36.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	59,655.8	182,119.5	122,463.8
Авлага	360,313.2	4,149,520.1	3,789,206.9
Бараа материал	48,953.7	193,597.6	144,643.8
Урьдчилж төлсөн зардал	775,156.8	775,156.8	-
Бусад эргэлтийн хөрөнгө	1,092,344.5	1,092,344.5	-
Үндсэн хөрөнгө	7,609,472.7	7,168,642.7	(440,829.9)
Нийт хөрөнгө	9,945,896.7	13,561,381.2	3,615,484.6
Өр төлбөр	202,532.8	5,352,933.7	5,150,400.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,743,363.9	8,208,447.6	(1,534,916.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,945,896.7	13,561,381.2	3,615,484.6

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 122,463.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны орлого өссөнөөс шалтгаалсан;
2. Авлагын дансны үлдэгдэл 3,789,206.9 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын 2025 оны үйл ажиллагааны давсан орлого 3,752,278.1 төгрөг, Төлбөр хураах цэгийн ажилчидтай холбоотой авлага 22,214.5 мянган төгрөгөөр, байгууллагаас авах авлага 12,003.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн;
3. Бараа материал дансны үлдэгдэл 144,643.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Төлбөр хураах цэгийн ажилтнуудын өвөл, зуны хувцас 104,490.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь голлон нөлөөлсөн;
4. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 440,829.9 мянган төгрөгөөр өссөн тайлант оны хуримтлагдсан элэгдэл 444,574.2 мянган төгрөг, тайлант онд 3,744.3 мянган төгрөгөөр компьютер тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалсан;
5. Өглөгийн дансны үлдэгдэл 5,150,400.9 мянган төгрөгөөр өссөн нь 3 гүйцэтгэгчид олгох ажлын гүйцэтгэл 3,636,297.7 мянган төгрөг, Төлбөр хураах цэгийн ажилчидтай холбоотой цалин, нийгмийн даатгал ХХОАТ-ын өглөг 684,325.5 мянган төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 885,023.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, өмнөх оны 1

гүйцэтгэгчид төлөх өр төлбөр 55,245.6 мянган төгрөгийг барагдуулснаас шалтгаалсан; Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,208,447.6 мянган төгрөг болж өмнөх оноос 1,534,916.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхэд урсгал зардлыг 6,588,084.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 178,202,636.4 мянган төгрөгөөр нийт 184,790,720.5 мянган төгрөгөөр төлөвлөж, улсын төсвөөс 159,790,720.5 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогоос 25,000,000.0 мянган төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн ирүүлсэн төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 1,232,084.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 62,612,685.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 120,945,950.8 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 90,589,950.8 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогоос 30,356,000.0 мянган төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр баталжээ.

Тайлант онд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, хөрөнгийн зардлыг батлагдсан төсвөөс 42,794,975.4 мянган төгрөгөөр бууруулан нийт зардлыг 78,150,975.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 42,794,975.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 34,349,200.8 мянган төгрөгийг бүрдүүлж, 30,356,000.0 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 3,993,200.8 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 78,150,975.4 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71101 Авто зам					
1	210801 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,356,000.0	5,356,000.0	-	100.0%
2	223001 Хөрөнгийн зардал	47,794,975.4	47,794,975.4	-	100.0%
Нийт дүн		78,150,975.4	78,150,975.4	-	100.0%

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Тайлант онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн 9 хувийн цомхотголтой холбоотойгоор үндсэн 16, гэрээт 235 нийт 251 орон тооноос үндсэн 5 хасаж, шинээр төлбөр авах цэг байгуулж буйтай холбоотой гэрээт 237 болгон нэмэгдүүлж нийт 248 орон тоотой болгон нийт 3 орон тоог бууруулж бүтэц орон тоогоо шинэчлэн баталсан;

- “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирлын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/68 дугаар тушаалаар нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийн хэмжээг өдрийн 15.0 мянган төгрөг, унааны хэмжээг өдрийн 5.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Тайлант онд нийт гадаад албан томилолт зардал зарцуулаагүй;
- Албан хаагчдад чиглэсэн 2 удаагийн чадавхжуулах сургалтад 1,611.7 мянган төгрөг, Төлбөр авах цэгүүдийн тайлангийн хурал зохион байгуулахад 12,960.0 мянган төгрөгийг зарцуулсан;
- Үндсэн хөрөнгийн дансанд санхүү, нягтлан бодох бүртгэлийн 3, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2 нийт 5 программ бүртгэлтэй бөгөөд үүнээс санхүү, нягтлан бодох бүртгэлийн Unicus программ ашигладаг.
- Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс шалтгаалж ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас нөхөн олговрыг олгоогүй;
- Авто замын төлбөр хураах цэгийг цахимжуулсантай холбоотойгоор орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх, иргэдийг зам ашигласны төлбөр төлүүлэхтэй холбоотой 2 байгууллагатай гэрээ байгуулж 14,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Зам, тээврийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаалын хавсралтаар Улсын авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 41,641,169.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээг зохион байгуулахаар тусгажээ.

Гүйцэтгэлээр 33,765,646.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг гэрээг дүгнэсэн, 2,720,716.0 мянган 1 төсөл, арга хэмжээг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-аар гүйцэтгүүлж, 5,154,807.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүйгээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр хасагдсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын авто замын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Улсын авто замын сан түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор олон жилийн насжилттай бусад эргэлтийн хөрөнгө, урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй хөрөнгүүдийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх, байгуулсан гэрээ хэлцлийн дагуу урьдчилгаа төлбөрийг суутгах, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитор Ж.Мөнхбилгүүн нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03/693 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 61,195,266.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 611,952.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон, хязгаарласан гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, зочин төлөөлөгч хүлээн авах тайлант онд санхүүжүүлээгүй бөгөөд хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал батлагдаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 22,775,328.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 14,792,755.8 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улсын авто замын сан нь Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 107,914,179.1 мянган төгрөгийн 346 гүйлгээ мэдээлэхээс 36,214,273.3 мянган төгрөгийн 177 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 22,775,328.7 мянган төгрөгийн 61 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт орж Зам, тээврийн сайдын 2025 оны А/217 дугаар тушаалаар "Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын төлөвлөгөө"-г А/289, А/324 дүгээр тушаалаар тус тус шинэчилсэн ч гүйцэтгэгчидтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусгаагүйгээс гүйцэтгэгчид гэрээний дүнгээр өр төлбөр үүсгэх эрсдэл үүсгэсэн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. "Дорноговь аймгийн Замын-Үүд сумын тусгай зориулалтын авто замын уулзвараас төлбөр авах цэг хүртэлх 3.54 км авто замын өргөтгөл, төлбөр авах цэгийг шинэчлэн барих" ажлын 2 гүйцэтгэгчтэй байгуулсан нийт 15,419,035.8 мянган төгрөгийн гэрээг тодотголоор 4,133,955.8 мянган төгрөгөөр бууруулсны дагуу шинэчлээгүй;
2. "Улсын чанартай авто замд ээлжит засварын ажил гүйцэтгэх" ажлын 11 гүйцэтгэгчтэй байгуулсан нийт 25,000,000.0 мянган төгрөгийн гэрээг тодотголоор 10,658,800.0 мянган төгрөгөөр бууруулсны дагуу шинэчлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т "Захиалагчийн чиг үүрэг:" 4.2.2.1-д "төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь,

санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Тодотголоор төсөв буурсан ажлуудын гүйцэтгэгчидтэй байгуулсан гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусгах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: "Улсын чанартай авто замуудад хийгдэх хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгааны ажил гүйцэтгэх захиалагч зөвлөхийн хооронд байгуулах гэрээ"-ний гүйцэтгэгч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, тайлан, гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд ирүүлээгүй, алданги тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т "Захиалагчийн чиг үүрэг:" 4.2.2.1-д "төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажлын хугацаа хэтэрсэн алданги тооцоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Улсын авто замын сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 16 дугаар зүйлийн 16.4-т "Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна:" 16.4.17-д "Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлэх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, мөнгөн хөрөнгө, хөрөнгийн зардалд аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитын үр дүнд нийт 33,466,764.3 мянган төгрөгийн дүн бүхий 7 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд эдгээр асуудлын хэрэгжилт, залруулсан байдлыг жилийн эцсийн аудитаар дахин хянан шалгаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 43,619,682.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 680.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 39,696,359.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 3,922,643.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн хэрэгжилт 73.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	680.6	1	680.6	100.0
Албан шаардлага	3	39,696,359.2	-	19,496,479.1	21.2
Зөвлөмж	1	3,922,643.0	1	3,922,643.0	100.0
Нийт дүн	5	43,619,682.8	2	23,419,802.7	73.3

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 39,696,359.2 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлагуудын хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх аудитаар илэрсэн хэрэгжилт хангалтгүй дараах асуудлуудыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн анхааралд хандуулан шийдвэрлүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Улсын авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх олон улсын болон улсын чанартай авто зам арчлалт, засварын ажлын төсөвт өртгийг бууруулснаас тайлант онд гүйцэтгэгч байгууллагад төлөх ажлын гүйцэтгэлийн өглөг үүссэн, төлбөр хураах үйл ажиллагааны албан хаагчдын нийгмийн баталгаа алдагдах эрсдэл дагуулж байна.
2. Хүний нөөцийн тогтвор суурьшилтай байдлыг хангаж ажиллаагүйгээс өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, удирдлагын үүрэг, хариуцлагыг хүлээх орон тоо эзэнгүйдэх нөхцөл бий болж, байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Улсын авто замын сан

Аудитаар УСНББОУС 1, 24, 27 дугаар заалтад нийцээгүй нийт 4,259,188.8 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд бусад эргэлтийн бус хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 75,190.1 мянган төгрөгөөр илүү, богино хугацаат зээлийн өглөгийн эхний үлдэгдлийг дутуу тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд нийгмийн даатгалд шимтгэлийн зардлыг 550,412.2 мянган төгрөгөөр дутуу, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг илүү тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайланд 4 гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үлдэгдэл 3,633,586.4 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан;

Аудитаар нийт 7,382,869.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 976,117.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 6,406,751.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн 7,382,869.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 611,952.7 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.2 Харьяа байгууллага

Төлбөр хураах цэгийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,650,102.3 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс 76,337.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 4,220.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 104,490.0 мянган төгрөгийн зөрчил таслан зогсоох 1, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 26,138.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна. Нийцлийн аудитаар 2,440,063.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнээс 2,440,063.3 мянган төгрөгийн төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

5.3 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Нийт 370,846.4 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үүнээс өмнөх онд гүйцэтгэгчид илүү олгосон санхүүжилтээс үүссэн 350,738.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Өр төлбөрийн данстай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Нийт 605,271,315.00 /Зургаан зуун таван сая хоёр зуун далан нэгэн мянга гурван зуун арван таван/ төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;

2. Тайлант оны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүйгээс нийт өглөгийн 308,308,189.00 /Гурван зуун найман сая гурван зуун найман мянга нэг зуун наян есөн/ төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 404,007,689.00 /Дөрвөн зуун дөрвөн сая долоон мянга зургаан зуун наян есөн/ төгрөг нь ХХОАТ-ын өглөг, 103,437,018.00 /Нэг зуун гурван сая дөрвөн зуун гучин долоон мянга арван найман/ төгрөг нь ажилчдад өгөх цалингийн өглөг байгаа нь ажиллагсдын нийгмийн баталгаа алдагдах эрсдэл үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.5 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Улсын авто замын сангийн эх үүсвэрээр 2020-2023 онд гүйцэтгэсэн 9 ажлын 1,092,344.5 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, бусад эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлж, холбогдох байгууллагуудад шилжүүлэх.

2. Урьдчилж гарсан зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Улсын авто замын сангийн эх үүсвэрээр 2020 онд гүйцэтгэсэн ажлын 775,156.8 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Олон жилийн насжилттай урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан холбогдох байгууллагуудад шилжүүлж бүртгүүлэх.

3. Урьдчилгаа төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 3: Нийт 2 гүйцэтгэгчтэй байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний суутгаагүй үлдсэн урьдчилгаа 140,990.5 мянган төгрөгийг гүйцэтгэгчдийн "Улсын чанартай авто замын байгууламжид хийгдсэн онцгой ажлын гэрээ"-ний гүйцэтгэлээс суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх,"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх,"; Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.Захиалагчийн чиг үүрэг: 4.2.2.1-д "төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах", "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний 2.8-д "Урьдчилгаа санхүүжилт нь хийгдсэн үе шатны ажлын дагуу гүйцэтгэгчид төлөх санхүүжилтийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэн төлөгдөх ба олгосон урьдчилгаа санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавьж, хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлээс 12 дугаар сарын 01-ний дотор суутгаж дууссан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгуулсан гэрээ хэлцлийн дагуу олгосон урьдчилгаа төлбөрийг гэрээ байгуулсан ажлын гүйцэтгэлээс суутгах.

4. Урьдчилгаа төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 4: Нийт 4 гүйцэтгэгчтэй байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний урьдчилгаа төлбөр 4,398,259.7 мянган төгрөгийг гэрээнд заасан хугацаанд суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх,"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх,"; Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.Захиалагчийн чиг үүрэг: 4.2.2.1-д "төсөл, арга хэмжээний

гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах", "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний 2.8-д "Урьдчилгаа санхүүжилт нь хийгдсэн үе шатны ажлын дагуу гүйцэтгэгчид төлөх санхүүжилтийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэн төлөгдөх ба олгосон урьдчилгаа санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавьж, хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлээс 12 дугаар сарын 01-ний дотор суутгаж дууссан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгуулсан гэрээ хэлцлийн дагуу урьдчилгаа төлбөрийг ажлын гүйцэтгэл тус бүрээс гэрээнд заасан хугацаанд суутгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1. Улсын авто замын сан****6.1.1. Улсын авто замын сангийн Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын авто замын сан											
1	Санхүүгийн байдлын тайланд бусад эргэлтийн бус хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 75,190.1 мянган төгрөгөөр илүү, богино хугацаат зээлийн өглөгийн эхний үлдэгдлийг дутуу тайлагнасан.	1	75,190.2			1	75,190.2	1	75,190.2		
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд нийгмийн даатгалд шимтгэлийн зардлыг 550,412.2 мянган төгрөгөөр дутуу, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг илүү тайлагнасан.	1	550,412.2			1	550,412.2	1	550,412.2		
3	Санхүүгийн байдлын тайланд 4 гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үлдэгдэл 3,633,586.4 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан	1	3,633,586.4	1	3,633,586.4			1	3,633,586.4		
	Дүн	3	4,259,188.8	1	3,633,586.4	2	625,602.4	3	4,259,188.8		

6.1.2. Улсын авто замын сангийн Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Бусад эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй, Улсын авто замын сангийн хөрөнгөөр 2020-2023 онд гүйцэтгэсэн 9 ажлын 1,092,344.5 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй үлдэгдэлтэй байна.	1	1,092,344.5							1	1,092,344.5		
2	Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй, Улсын авто замын сангийн хөрөнгөөр 2020 онд гүйцэтгэсэн ажлын 775,156.8 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй үлдэгдэлтэй байна.	1	775,156.8							1	775,156.8		
3	Нийт 370,846.4 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үүнээс өмнөх онд гүйцэтгэгчид илүү олгосон санхүүжилтээс үүссэн 350,738.2 мянган төгрөгийн барагдуулаагүй авлага байна.	1	370,846.4			1	370,846.4						
4	Өглөгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: 1. Нийт 605,271.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй; 2. Тайлант оны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүйгээс нийт өглөгийн 308,308.2 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 404,007.7 мянган төгрөг нь ХХОАТ-ын өглөг, 103,437.0 мянган төгрөг нь ажилчдад өгөх цалингийн өглөг байгаа нь ажиллагсдын нийгмийн баталгаа алдагдах эрсдэл үүсгэж байна	1	605,271.3			1	605,271.3						
5	Нийт 2 гүйцэтгэгчтэй байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт,	1	140,990.5							1	140,990.5		

	засварын ажил гүйцэтгэх" гэрээний суутгаагүй үлдсэн урьдчилгаа 140,990.5 мянган төгрөгийг гүйцэтгэгчдийн "Улсын чанартай авто замын байгууламжид хийгдсэн онцгой ажлын гэрээ"-ний гүйцэтгэлээс суутгасан байна.									
6	Нийт 4 гүйцэтгэгчтэй байгуулсан "Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2025 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх" гэрээний урьдчилгаа төлбөр 4,398,259.7 мянган төгрөгийг гэрээнд заасан хугацаанд суутгаагүй байна.	1	4,398,259.7					1	4,398,259.7	
	Дүн	6	7,382,869.2	-	-	2	976,117.8	4	6,406,751.5	

6.1.3. Улсын авто замын сангийн Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: 1. Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан; 2. Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 107,914,179.1 мянган төгрөгийн 346 гүйлгээ мэдээлэхээс 36,214,273.3 мянган төгрөгийн 177 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 22,775,328.7 мянган төгрөгийн 61 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	22,775,328.7	1	22,775,328.7		
	Дүн	1	22,775,328.7	1	22,775,328.7		
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын 2025 оны А/217 дугаар тушаалаар "Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын төлөвлөгөө"-г А/289, А/324 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн баталсантай холбоотой гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусгаагүй дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:	1	14,792,755.8			1	14,792,755.8

	1. "Дорноговь аймгийн Замын-Үүд сумын тусгай зориулалтын авто замын уулзвараас төлбөр авах цэг хүртэлх 3.54 км авто замын өргөтгөл, төлбөр авах цэгийг шинэчлэн барих" ажлын 2 гүйцэтгэгчтэй байгуулсан нийт 15,419,035.8 мянган төгрөгийн гэрээг тодотголоор 4,133,955.8 мянган төгрөгөөр бууруулсны дагуу шинэчлээгүй; 2. "Улсын чанартай авто замд ээлжит засварын ажил гүйцэтгэх" ажлын 11 гүйцэтгэгчтэй байгуулсан нийт 25,000,000.0 мянган төгрөгийн гэрээг тодотголоор 10,658,800.0 мянган төгрөгөөр бууруулсны дагуу шинэчлээгүй байна.						
2	"Улсын чанартай авто замуудад хийгдэх хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгааны ажил гүйцэтгэх захиалагч зөвлөхийн хооронд байгуулах гэрээ"-ний гүйцэтгэгч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, тайлан, гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд ирүүлээгүй, алданги тооцоогүй байна.	1	-	1	-		
3	Улсын авто замын сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.	1	-			1	-
	Дүн	3	14,792,755.8	1	-	2	14,792,755.8
	Нийт дүн	4	37,568,084.6	2	22,775,328.7	2	14,792,755.8

6.2. Төлбөр хураах цэг**6.2.1. Төлбөр хураах цэгийн Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
								Залруулсан		Залруулаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн реклам сурталчилгааны төлбөр 76,337.8 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд бүртгэсэн.	1	76,337.8			1	76,337.8	1	76,337.8		
	Дүн	1	76,337.8			1	76,337.8	1	76,337.8		

6.2.2. Төлбөр хураах цэгийн Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
1	Тайлант онд 7 төлбөр хураах цэгт худалдан авсан 21,338.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй.	1	21,338.8							1	21,338.8		
2	Дотоод томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 3,920.0 мянган төгрөгийн зардлыг илүү тооцож олгосон байна.	1	3,920.0	1	3,920.0								
3	Дотоод албан томилолтоор ажилласан албан хаагчдын цалин хөлсийг тооцоолохдоо, томилолтоор ажилласан хугацаанд нийт 300.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгийг давхардуулан олгосон байна.	1	300.0	1	300.0								

СНАГ-2026/016/НА-СТА-ЗГТС

4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Төлбөр хураах цэгийн төсөвт тусгаагүй "Нягтлан бодох бүртгэлийн аутсорсингийн үйлчилгээ болон татварын зөвлөх үйлчилгээ"-ний 4,800.0 мянган төгрөгийн гэрээг нэр бүхий 1 байгууллагатай 15 хоногийн хугацаатайгаар байгуулсан байна. Гэрээгээр гүйцэтгэгч нь байгууллагын нягтлан бодогчийн үүрэг санхүүгийн бүртгэл, тайлагналын ажлыг гүйцэтгүүлсэн байна.	1	4,800.0					1	4,800.0		
5	Төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль, тогтоомж, батлагдсан загварын дагуу иж бүрэн бэлтгэж, ирүүлээгүй байна.	1	-					1	-		
6	Худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан "Ажилчдын өвөл, зуны ажлын тусгай хувцас худалдан авах" ажлын гэрээг нэр бүхий 1 компанитай 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр байгуулж, гэрээт ажлын гүйцэтгэлийн төлбөр 104,490.0 мянган төгрөгийг тайлант онд ЗТХТ ТӨҮГ-аас өглөг үүсгэн гүйцэтгэгчид олгосон байна.	1	104,490.0			1	104,490.0				
7	Өмнөх оны аудитаар өгсөн нийт 317,703.3 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлүүд давтан гарсан байна. Үүнд: 1. Батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоох 47,703.3 мянган төгрөг; 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, худалдан авсан хөрөнгийг бүртгэх 270,000.0 мянган төгрөг;	1	-							1	1
Дүн		7	134,848.8	2	4,220.0	1	104,490.0	3	26,138.8	1	1

6.2.3. Төлбөр хураах цэгийн Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд 1. Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээлэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроон байршуулсан; 2. Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 48,157,595.6 мянган төгрөгийн 1015 гүйлгээ мэдээлэхээс 4,871,851.9 мянган төгрөгийн 148 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2,410,583.3 мянган төгрөгийн 23 гүйлгээг мэдээлээгүй; 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь тогтмол байршуулах" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, ЗТХТ ТӨҮГ-аас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хэрэгжүүлсэн дотоод аудит үр нөлөөгүй байна.	1	2,410,583.3	1	2,410,583.3		
	Дүн	1	2,410,583.3	1	2,410,583.3		
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	"Түргэний гүүрийн төлбөр авах цэгийн гарах хэсгийн ХК3190-М1 заагч индикатортой 30тн даац бүхий динамик хэмжлийн автопүүний электрон эд ангиудыг шинээр сольж суурилуулах" ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хувааж нэр бүхий 1 компанитай 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр 15,840.0 мянган төгрөгийн болон 13,640.0 мянган төгрөгийн тус тус 2 гэрээг байгуулсан байна.	1	29,480.0	1	29,480.0		
2	Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна. Тухайлбал, НБББББ-ийн 4.4.2.а Машин тоног төхөөрөмжид уран бүтээлийн зориулалттай тоног төхөөрөмж, компьютер, дэлгэц, тайз, дэлгэцийн гэрэлтүүлгийн техник хэрэгсэл, дуу шуумны хэрэгсэл, камер, бичлэгийн тоног төхөөрөмж, тайзны механизм, хөргөлтийн болон утааны төхөөрөмж зэрэг орно. Тавилга, аж ахуйн эд хогшилд Уран бүтээлчдийн нүүр будгийн ширээ, сандал, шкаф, хөгжимчдийн нотны тавиур, сандал, хөгжмийн шкаф, тоглолтод хэрэглэгддэг тайзны жижиг хэрэгсэл зэргийг бүртгэнэ. Бусад хөрөнгөд байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд ардын болон утсан хөгжим, цохивор хөгжим, үлээвэр хөгжим, даралтат болон чавхдаст хөгжмүүдийг бүртгэнэ гэж заасан байна.	1	-			1	-

3	Төрийн аудитын байгууллагаас 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй байна.	1	-			1	-
	Дүн	3	29,480.0	1	29,480.0	2	-
	Нийт дүн	4	2,440,063.3	2	2,440,063.3	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1066/АД170104

Улаанбаатар хот

САГ - 2026/16/НА - ЛТА - ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

"Улсын чанартай авто замуудад хийгдэх хөдөлгөөний эрчмийн тооллого, судалгааны ажил гүйцэтгэх захиалагч зөвлөхийн хооронд байгуулах гэрээ"-ний гүйцэтгэгч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, тайлан, гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд ирүүлээгүй, алданги тооцоогүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т "Захиалагчийн чиг үүрэг:" 4.2.2.1-д "төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, тайлан, гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд ирүүлээгүй, алданги тооцоогүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Сумъяа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga.2026/0325 SAG-6.Docx

1526181324



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1067/АД170104

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт 370,846,441.00 /Гурван зуун далан сая найман зуун дөчин зургаан мянга дөрвөн зуун дөчин нэгэн/ төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үүнээс өмнөх онд гүйцэтгэгчид илүү олгосон санхүүжилтээс үүссэн 350,738,117.00 /Гурван зуун тавин сая долоон зуун гучин найман мянга нэг зуун арван долоон/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг тооцоо нийлж, барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Сумъяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-6.Docx

1526181320



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1068/А0170104

Улаанбаатар хот

САГ-2026/16/КА -СТА -ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Нийт 605,271,315.00 /Зургаан зуун таван сая хоёр зуун далан нэгэн мянга гурван зуун арван таван/ төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
2. Тайлант онд төсвийг зохистой удирдаагүйгээс нийт өглөгийн 308,308,189.00 /Гурван зуун найман сая гурван зуун найман мянга нэг зуун наян есөн/ төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 404,007,689.00 /Дөрвөн зуун дөрвөн сая долоон мянга зургаан зуун наян есөн/ төгрөг нь ХХОАТ-ын өглөг, 103,437,018.00 /Нэг зуун гурван сая дөрвөн зуун гучин долоон мянга арван найман/ төгрөг нь ажилчдад өгөх цалингийн өглөг байна. Энэ нь ажиллагсдын нийгмийн баталгаа алдагдах эрсдэл үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Сумъяа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭВГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26-230

9006109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-6.Docx

1526181322



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1069/АД170104

Улаанбаатар хот

САГ-2026/16/НА - СТА - ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан;

2. Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 107,914,179,126.00 /Нэг зуун долоон тэрбум есөн зуун арван дөрвөн сая нэг зуун далан есөн мянга нэг зуун хорин зургаан/ төгрөгийн 346 гүйлгээ мэдээлэхээс 36,214,273,259.00 /Гучин зургаан тэрбум хоёр зуун арван дөрвөн сая хоёр зуун далан гурван мянга хоёр зуун тавин есөн/ төгрөгийн 177 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 22,775,328,733.00 /Хорин хоёр тэрбум долоон зуун далан таван сая гурван зуун хорин найман мянга долоон зуун гучин гурван/ төгрөгийн 61 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Б.Болор-Эрдэнэ/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Сумъяа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 9-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-6.Docx

1526181326